



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/115

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хог хаягдлын тухай хуулийн 9.1.3-т заасан “энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”, 9.1.4-т заасан “нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф”, 9.1.5-д заасан “Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгох журам”, 9.3.3-т заасан “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох журам”-ын төслийг тус тус боловсруулах Ажлын хэсгийг хавсралтаар байгуулысугай.

2. Хог хаягдлын тухай хуульд заасан дээрх эрх зүйн актын цогц төслийг хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд 2019 оны 05 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг Ажлын хэсэг /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  С.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 04 дугаар сарын 23-ний өдрийн
А/115 дугаар тушаалын хавсарлт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Чинсанаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн зарлагын эдийн засагч
	Т.Энх-Амгалан	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн хог хаягдлын дахин боловсруулалт, эцсийн устгалын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн хууль, эрх зүйн мэргэжилтэн
	Н.Пүрэвжав	"Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын орлогч дарга
	Б.Жаргал	"Хотын хөгжлийг дэмжих шинэ тосгон хөдөлгөө" ТББ-ын тэргүүн
	А.Мягмардолжин	"Эмэгтэйчүүдийн эрх хамгаалал, хөгжлийн хүрээлэн" ТББ-ын тэргүүн
	А.Нямдорж	"Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн" ТББ-ын тэргүүн
	Ч.Энхжаргал	"Бид туслая" ТББ-ын тэргүүн
	П.Цэндмаа	"Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо" ТББ-ын гүйцэтгэх захирал
	Б.Дэлгэрбаяр	Нэгдсэн үндэсний байгууллагын аж үйлдвэрийн газрын "Хог хаягдлаас үүдэх ил шаталтыг бууруулах" төслийн зохицуулагч /Зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	С.Аригуун	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн хог хаягдлын бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн